

1. Газарзүйн байршил

Бөхөгийн хөндийн орд нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт “Очирням” ХХК-ийн эзэмшиж буй 12215А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн L-48-10 тоот хавтгайд хамрагдах

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | |
|---------------|--------|-------|--------|---------|-------|--------|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 106 | 34 | 50 | 47 | 44 | 46 |
| 2 | 106 | 35 | 15 | 47 | 44 | 46 |
| 3 | 106 | 35 | 15 | 47 | 44 | 26 |
| 4 | 106 | 35 | 10 | 47 | 44 | 26 |
| 5 | 106 | 35 | 10 | 47 | 44 | 10 |
| 6 | 106 | 34 | 50 | 47 | 44 | 10 |

цэгүүдээр хязгаарлагдсан 52 гектар талбайг хамран, Улаанбаатар хотоос урагш 35 км چаёё, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг Шувуун фабрикаас урагш 1.3 км-т идөёй.

2 . Физик газарзүй, байгаль, цаг уурын нөхцөл


Газарзүйн байрлалын хувьд Хэнтийн уулархаг мужийн өмнөд хэсэгт Бөхөг голын хөндийд харьяалагдана. Судалгааны талбай орчмын уулсын харьцангуй өндөр 1300-1500м, хөндийн туйлын өндөржилт нийт талбайн хэсэгт 1225.98-1230.69 м байна. Талбайн гадаргуугийн талбайн рельеф нь бараг тэгшивтэр, голын урсгалын дагуу зүүн урдаас баруун хойш ургаш чиглэсэн доош суусан маягын гадаргуу үүсгэжээ.

Усан сүлжээний хувьд ордын орчимд Туул, Бөхөгийн голуудтай. Талбайн дундуур Бөхөгийн гол дайран өнгөрдөг ба тогтмол урсацгүй, тухайн жилийн хур хундасны хэмжээнээс шалтгаалан урсдаг байна.

Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур дундас багатай хуурай агаартай, цаг агаарын олон жилийн ажиглалтын дунджаар хамгийн хүйтэн 12-1-р сард болдог ба $-25-30^{\circ}\text{C}$ хэм, хамгийн халуун үе 6-8-р сард болдог бөгөөд $+25+30^{\circ}\text{C}$ хэм байдаг. Жилийн дундаж хур хундасны хэмжээ 200-250 мм ба үүний дийлэнх (150-180мм) нь 6-9сард бороо хэлбэрээр буудаг байна. Талбайн орчимд олон жилийн цэвдэгшлийн бүс тааралддаггүй. Салхий гол төлөв баруун хойноос зүүн ургаш

чиглэлтэй, салхины жилийн дундаж хурд 4.7м/сек гэх боловч хавартаа 10-15 м/сек
хүрэх тохиолдолд элбэг.

Шимт хөрсний зузаан 10-20 см, зарим тохиолдолд 40 см хурдэг. Шар хүрэн,
элсэрхэг хөрстэй. Ургамалын бүрхэвч сийрэг, тааруу, голдуу хээрийн бүсийн ургамал
ургадаг. Ан амьтадаас үнэг, хярс, чоно, уулархаг хэсэгтээ тavarга тааралдана.



Бөхөгийн хөндийн ордын байршлын зураг

2004 онд 6929Х хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Бөхөг-солонго нэртэй хайгуулын талбайд “Солонго бил” ХХК нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэж, нөөцийн тайланг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 28-04 тоот хуралдаанаар хэлэлцүүлж, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2008 оны 08 дугаар сарын 416 тоот тушаалаар ордын 1173.4 мяняган m^3 элс-хайрганы нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

3. Бөхөгийн хөндийн элс-хайрганы ордын геологийн тогтоц

Ордын тогтоц

Бөхөгийн хөндийн ордын элс-хайрганы хольц нь өмнө нь 1986 онд тогтоогдож эрэл үнэлгээний ажлаар тодорхой хэмжээнд судлагдсан. /Геологич Ж.Цэрэндорж/ Бөхөг-Солонгын орд нь Бөхөг голын элс-хайрганы хольцын үргэлжлэл юм. Талбайд тархсан хэмхдэс чулуулгийн зузаалаг нь аллювийн голдрил, сайраас тогтох ба энэ нь нэг төрлийн элсэргэх-хайргархаг-хайрган материалыас бүрдэнэ. Эдгээр материал нь ерөнхийдөө саарал, шаравтар-саарал өнгөтэй байна. Элс хайрганы чулуулагт элсний агуулга 35.5 %, 5-40 мм-ийн хэмжээтэй хайрга 64.7%, 70 мм-ээс том хэмжээний валун 0.16% буюу бараг байхгүй.

Бүдүүн хэмхдэст материалын хэлбэр нь дугуйрсан сайн мөлгөржсөн, гадаргуу нь толигор байна. Петрографийн найрлагаараа том ба бүдүүн хэмхдэст материал нь голлон метаморфичлогдсон элсэн чулуу, бялхмал бөсөл чулуулаг түүнчлэн филлитлэгдсэн занар, алеврит-цахиурлаг-шаварлаг занар, боржин ба түүний дресва, маш багаар микродиорит, диорит-порфирият, хүчиллэг найрлагатай бялхмал чулуулгаас тогтсон хайргаас бүрдэнэ. Хайрганцар, хайрга болон жижиг валун нь ихэнхдээ бат бэх, нягт, хатуу байна. Бүдүүн хэмхдэст материалын хэмжээнд хэврэг бө өгөршсөн чулуулгийн мөхлөг дунджаар 5-7%, лабораторийн судалгаагаар хэврэг чулуулгийн мөхлөгийн агуулга 5-20 мм-ийн хайрганд 13.25%, 20-40 мм хайрганд 12.7% байна.

Хэврэг болон өгөршсөн чулуулгийн мөхлөг гол төлөв хувиралд орсон аркоз элсэн чулуу, заримдаа витрокластик туф, зарим тохиолдолд филлитчилэгдсэн алеврит шаварлаг занарт илрнэ. Мөхлөгийн хэлбэр нь дугуйрсан мөш ховоор өнцөглөсөн, мөхлөгийн мөлгөржилт сайн, гадаргуу нь толигор байна.

Хайрга, хайрганцар нь петрографийн найрлага болон хэврэг чулуулгийн мөхлөгийн агуулга түүнчлэн мөхлөгийн хэлбэр нь мөөгөржилт элэгдэлт нь хайгуулын талбайн хэмжээнд, мөн гүн рүүгээ өөрчлөлтгүй болно.

Бүдүүн хэмхдэст материалд хавтгайлаг, үзүүрлэг хэсгийн мөхлөгийн агуулга 13.8-19.3% хүртэл хэлбэлзэнэ.

Элс-хайрганы хольцын 2.5 мм-ээс бага хэсгийг /элсийг/ лабораторын нөхцөлд шинжлүүлэн судалгаа хийлгэхэд элсний мөхлөг нь мөлгөржилт сайтай, бэржгэр гадаргуутай. Шигшсэн элс нь ерөнхийдөө дунд том ширхэгтэй, элсний ширхэгийн модуль 2.5-3.81, дунджаар 3.08 байна. Эндээс үзэхэд ордын хэмжээнд элс нь том ширхэгтэй байна. Элс нь өөрийн жингээрээ шавар, наангилаг шавар, тоосорхог хольц болон органик хольцоос амархан ялгарч байна.

Органик хольц нь этоленоос цайвар байгаа нь шаардлагын хэмжээнд байгааг харуулж байна. Элсэнд гялтагануур, карбонатлаг, кальцитлаг эрдсийн хольц байхгүй. Элсэн дэхь шаварлаг тоосорхог хэсгийн агуулга 0.56-2.35%, дунджаар 1.28% байсан.

Хайгуул хийсэн талбайн хэмжээнд элс-хайрганы хольцын зузаан нь 4.4-4.9 м, дунджаар 4.64 м байв. Элс- хайрганы хольцын чанар талбайн төрхөлт болон гүндээ жигд байна.

Элс хайрганы хольцын ашигт зузаалаг гадаргуугаас хуулга хөрсний зузаан ба хөрс ургамлын үеийн доор 0.1-0.6 м-т давхарга, хэвтэш маягийн хэвтээ байрлалтай тогтоцтой болно. Хайгуул хийсэн талбайн хэсэгт 5м хүртэл гүн шуфт нэвтрэлт хийхэд хөрсний ус тааралдаагүй тул элс-хайрганы хольцын нөөцийг тооцоолохдоо устай давхарга гэж ялгаагүй, зөвхөн усгүй давхаргаар нөөцийг тооцоолсон байна.

4. Нөөцийн тооцооны үр дүн

Ордын талбайн хэмжээ 25.3 га, ашигт давхаргын дундаж зузаан 4.60 м, хучаас хурдасны дундаж зузаан 0.47 м, элсний нөөц баттай (A), бодитой (B) зэргээр 414283.9 м³, хайрганы нөөц баттай (A), бодитой (B) зэргээр 759148.9 м³, нийт элс-хайрганы нөөц 1173433 м³, хучаас хурдасны эзэлхүүн 114027 м³, хөрс хуулалтын итгэлцүүр 1/10 байна.

Бөхөгийн хөндийн элс-хайрганы ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

| Нөөцийн зэрэг, блокын дугаар | Ашигт давхаргын зузаан /м/ | | Талбай н хэмжээ /м2/ | Эзэлхүүн /м3/ | | Нөөц хэсгүүдийн агуулга /%/ дэх | | Ашигт малтмалын нөөцийн хэмжээ /м3/ | |
|------------------------------|----------------------------|-------------|----------------------|---------------|---------|------------------------------------|--------|-------------------------------------|----------|
| | хөрс | элс | | хөрс | элс | элс | хайрга | элс | хайрга |
| C-1 | 0.4 | 4.6 | 12782 | 5113 | 58797 | 35.81 | 64.19 | 21055.3 | 37741.9 |
| C-2 | 0.34 | 4.71 | 59900 | 20366 | 282129 | 35.17 | 64.83 | 99224.8 | 182904.2 |
| B-3 | 0.28 | 4.77 | 44000 | 12320 | 209880 | 34.84 | 65.16 | 73122.2 | 136757.8 |
| B-4 | 0.49 | 4.69 | 42700 | 20923 | 200263 | 35.21 | 64.79 | 70512.6 | 129750.4 |
| C-5 | 0.67 | 4.51 | 57440 | 38485 | 259054 | 35.47 | 64.53 | 91886.6 | 167167.8 |
| B-6 | 0.3 | 4.7 | 24000 | 7200 | 112800 | 36.98 | 63.02 | 41713.4 | 71086.6 |
| C-7 | 0.8 | 4.2 | 12026 | 9621 | 50509 | 33.20 | 66.80 | 16769.1 | 33740.1 |
| Дүн | | | 252848 | 114027 | 1173433 | 35.24 | 64.76 | 414283.9 | 759148.9 |
| Дундаж | 0.47 | 4.60 | | | | | | | |

5. УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ, АШИГЛАХ ХУГАЦАА

5.1. Уурхайн жилийн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг төсөл захиалагч компанийн даалгаврын дагуу 6.42 мянян.³ хөрс хуулалт хийж, 130 мянян.³ элс-хайрганы холимог олборлохоор уулын ажлын төлөвлөгөөнд тусгав.

5.2. Уурхайн ажиллах горим

Уурхай нь 5-р сарын 1- нээс 10-р сарын 1 хүртэл 6 сар ажиллана.

Тус уурхай нь жилийн баяр ёслолын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд ажиллана.

Жилд ажиллах хоногийн тоо:

- Жилийн нийт ажиллах хоног - 214
- Баяр ёслолын хоног - 4
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зарцуулах хоног - 20
- Цаг уур, нүүдэл, сэлбэгийн хангамжийн saatlaas сул зогсох хоног - 10

Уурхайн цэвэр ажиллах хоног: 214 – 4 – 20 – 10 = 180 хоног

- Хоногт ажиллах ээлж – 1
- Ээлжийн үргэлжлэх хугацаа- 8 цаг

2023 оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

| | 4 | 5 | 6 | Эхний хагас жил | 7 | 8 | 9 | 10 | 11 | Сүүлийн хагас жил | Нийт |
|---|----------|------------|------------|------------------------|------------|-------------|-----------|-----------|-----------|--------------------------|-------------|
| Хөрс хуулалт мян.м³ | - | 1.5 | 1.5 | 3.0 | 1.5 | 1.92 | | | | 3.42 | 6.42 |
| Элс хайрга олборлолт мян.м³ | | 26 | 26 | 52,0 | 26 | 26 | 26 | | | 78 | 130 |

6. Ашиглалтын систем

Төсөл хэрэгжүүлэгч Очириам ХХК нь уг тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэгт байрлах элс хайрганы талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд энд ажиллаж байсан тоног төхөөрөмжүүд нь бэлэн байгаа юм. Иймд уг хөрс хуулалтын ажилд тус төсөл хэрэгжүүлэгчид бэлэн байгаа Шантуй SD16 маркийн БНХАУ-д үйлдвэрлэсэн бульдозерыг ашиглахаар төлөвлөгөөнд тусгалаа.

Бульдозерын техникийн үзүүлэлт

Үзүүлэлт SD16 Зүтгэх хүч, кН 410

Хөдөлгөөний хамгийн их хурд, км/цаг 12

1-р араагаар явах хурд, км/цаг 3.0

Ухрах араагаар явах хурд, км/цаг 6.2

Хусуурын өндөр, өргөн, м 1.75; 3.24

Хөдөлгүүрийн чадал, мх 195

Оврын хэмжээ, м 5.4 x 3.1

Огтлох хэмжээ, м 0.66

Сийрэгжүүлэх гүн, м 0.98

Өөрийн жин, тн 16

Мөн ашиглахад бэлэн байгаа Hyundai 450LC маркийн 2.5 м3 утгуурын багтаамж бүхий өмнө ашиглаж байсан экскаваторыг шууд авч ашиглах нь хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж, төслийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх давуу талтай гэж үзсэн. Бөхөг солонгын ил хамааруулан сонгосон.

. Экскаваторын техникийн үзүүлэлтийг доор үзүүлэв.

Hyundai 450 LC экскаваторын үзүүлэлт

Утгуурын багтаамж, м³ 2.5

Гарны урт, м 3.84

Ачилт хийх хамгийн их өндөр, мм 10426

Ачилтын хамгийн их радиус, мм 7840

Утгалтын хамгийн их өндөр, мм 7214

Ачилт хийх радиус, мм 6380

Их биеийн өргөн, мм 3410

Арын эргэлтийн радиус, мм 2970

Хамгийн их хурд, км/ц 5.0

Масс, тн 45

Хөдөлгүүрийн чадал, кВт 365

Бөхөг солонгын ил уурхайгаас гарсан элс хайрганы холимогийг бутлан ангилах төхөөрөмж хүртэл тээвэрлэх ажилд ажиллах автосамосвалыг түүнд ачилт хийх экскаваторын утгуурын багтаамжаас хамааруулан сонгох нь зүйтэй юм. Бөхөг солонгын ил уурхайн элс хайрганы эзэлхүүн жин нь 1.85 тн/м³ байгаа учир бид автосамосвалын тэвш ашиглалтаар нь сонговол илүү зохимжтой юм. Иймд бид экскаваторын мөчлөгийн хугацаа харьцангуй бага учир 8 удаа утгалт хийхээр бодож тооцоход 18 м³ тэвшний багтаамжтай автосамосвал байх шаардлагатай юм. Иймд төсөл захиалагчид бэлэн байгаа Нордбенз маркийн 35 тонн даацтай автосамосвалыг элс хайрга тээвэрлэлтэнд ажиллуулахаар сонгон авлаа.

Нордбенз автосамосвалын техникийн үзүүлэлт

Автосамосвалын төрөл Нордбенз Даац, тн 35

Масс, тн 38.2

Тэвшний багтаамж, м³ 18

Хурд, км/ц 65

Эргэлтийн радиус, м 13

Хөдөлгүүр WNW840,36i

Хөдөлгүүрийн чадал, м.х 290

Дугуйн томъёо 8x2

Овор хэмжээ, урт– өргөн– өндөр, мм 6800x2870x3150

6.1.2. Бутлан ангилах процесийн технологи дараалал Уурхайгаас гарах элс хайрганы холимогийг боловсруулах ажлын технологи дараалал нь дараах бүдүүвч схемийн дагуу явагдана гэж үзсэн.

7. Дэд бүтэц

7.1. Цахилгаан эрчим хүчиний үүсгүүр

Ил уурхайн дотоод цахилгаан хангамжинд ерөнхий бууруулах дэд станцаас хэрэглэгч хүртэлх бүх төрлийн цахилгаан дамжуулах кабель шугам, зөөврийн ба суурин хуваарилах байгууламжууд, зөөврийн салгах пунктүүд орно. Уурхайг ерөнхий бууруулах дэд станцаас 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах шугамаар тэжээнэ. Уурхайн бутлуур, шигшүүр, тэжээгүүр, туузан дамжуулагч, кемп зэрэг цахилгаан хэрэглэгчдийг төвийн эрчим хүчиний системээс тэжээнэ

7.2. Уурхайн усан хангамж Тухайн талбай нь туул ай савд хамаарах бөгөөд уурхайн унд ахуйн хэрэглээний болон зам усалгааны усны эх үүсвэрийг тус талбайгаас 800 м зайд байрлах гүний худгаас авч ашиглана.

8. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уул уурхайн төслийн хүрэлэн буй орчны асуудал нь төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд уг төслийг хүрээлэн буй орчинд нөлөөлөлх нөлөөллийг багасгах, холбогдох стандартуудад нийцүүлэх, уурхайн үйл ажиллагаа ба уурхайн хаалтын явцад төлөвлөгөөгүйгээр үүсэн гарах ашиглалтын болон капитал зардлын улмаас үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулах замаар хүрээлэн буй орчны нөлөөллийг бууруулах чиглэлийг тодорхойлж энэхүү баримт бичигт тусгасан болно. Байгаль орчинд учирч болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган боловсруулж Байгаль орчны яамаар батлуулж ажиллана.

Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Одоогийн байдлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлд төслийн улмаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн боломжийн хэмжээнд урьдчилан тооцоолж, аль болох бага хэмжээнд байлгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах зүйлсийг тусгалаа. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гадаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилтод тулгуурлсан бөгөөд ашиглалтын 2 дахь жилийн сүүлийн хагасаас эхлэн эхний жилд ашигласан талбай, овоолгуудыг хэлбэржүүлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж эхэлнэ.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, чиглэлийг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайг тусгайлан байгуулж, онц шаардлагагүй зам гаргаж газрын гадарга эвдлэгдэхээс чанд сэргийлнэ.

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтын хувьд энэ үйл ажиллагааг оновчтой шийдэх зорилгоор тусгайлан журам боловсруулж мөрдүүлнэ. Уг зорилтын хүрээнд байгаль орчин болон хог хаягдлын талаархи хууль, тогтоомж, дүрэм, журмуудын дагуу олон улсын стандартын шаардлагаад нийцсэн арга технологийг хэрэгжүүлнэ.

Урьдчилан төлөвлөж байгаагаар Бөхөг-Солонго элс хайрганы ордыг ашиглахад хатуу хог, хаягдал гарахгүй гэж тооцож байгаа ба ажиллагсадаас үүдэлтэй хог хаягдлыг нэгдсэн журмаар зайлцуулна. Тоног төхөөрөмжийн эвдэрсэн эд ангиудыг цаашид ашиглахгүй тохиолдолд тусгайлан бэлтгэсэн талбайд цуглуулж, дараа нь уурхайн ашиглагдсан орон зайд булах боломжтой гэж үзэж байна.

Шингэн хог хаягдлын хувьд нефтийн бүтээгдэхүүний үлдэгдлээс бусад хаягдал гарахгүй гэж тооцоолж байгаа ба гарсан нефт бүтээгдэхүүний үлдэгдэл, хаягдлын мөн тусгайлан байгуулсан талбайд аваачиж хаяна.

Химиин хорт бодисын хувьд элс хайрганы ордыг ашиглахад химиийн хорт бодис ашиглахгүй тул энэ төрлийн хог хаягдал гарахгүй.

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь 2 үе шаттай хийгдэнэ.

1. Техникийн нөхөн сэргээлт :

2023 онд техникийн нөхөн сэргээлтийг 0.8 га талбайд хийж гүйцэтгэнэ.

Ил уурхайн ашиглалтын явцад хөрс хуулалтаар их хэмжээний хоосон орон зайд бүхий ухаш үүсдэг. Энэхүү ашиглагдсан хоосон орон зайд газрын гүний хурдас чулуулгийн гадаад ба кондицын бус хүдрийн овоолгоор дүүргэлт хийх, нөхөн дүүргэлт хийсэн талбайг орчных нь гадаргууд ойртуулан хэлбэршүүлэх, тэгшлэх ажиллагаанууд

хийгдэнэ. Ил уурхайнуудад ажиглагддаг түгээмэл зөрчил бол газрын гүнээс гарсан хурдас чулуулгийг эвдрэлд ороогүй эрүүл газарт эмх замбараагүй байдлаар их хэмжээний талбайг хамруулан овоолдог ба түүнээс гадна янз бүрийн агуулгатай хүдрийн овоолго үүсгэдэг. Энэ нь нэг талаас байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулж байгаа ба нөгөө талаас их хэмжээний шимт хөрс дээрх овоолгуудын доор дарагдаж ашиглах боломжгүй болох тул нөхөн сэргээлт хийхэд ихээхэн бэрхшээл гардаг.

Уурхайн ухшийн нөхөн сэргээлтийн ажил нь ухшийг нөхөн дүүргэх, хэлбэршүүлэх, тэгшлэх зэрэг ажлуудаас бүрдэнэ

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилго бүхий бэлтгэх арга хэмжээнүүд хамаардаг. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааны уул - техникийн үе шатанд дараах үндсэн үйл ажиллагаануудыг багтаадаг. Үүнд:

- Нөхөн сэргээлтэнд хамрагдах талбайг овор хэмжээ ихтэй уулын чулуулаг, үйлдвэрлэлийн байгууламжуудаас чөлөөлж, барилгын хог хаягдлыг цэвэрлэн тусгайлан зөвшөөрөгдсөн газарт булах эсвэл өөр ямар нэг зохион байгуулалттай байдлаар овоолгод байршуулах;
- Хөрс хуулалттай холбоотой үүссэн овон товон гадаргууг ерөнхийд нь сийрүүлэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан хэлбэршүүлэх, тогтвортжуулах, дэвсэгжүүлэн өндөрлөх, оройг намсах, ус зайлцуулах далан суваг шуудууг булж тэгшлэх, дэнжилсэн хана, мөргөцгийг налуулах, хэлбэршүүлэх ажиллагаанууд хийгдэж дараа нь нарийвчлан хэлбэржүүлж өнгөлөн тэгшлэх ажиллагааг гүйцэтгэх;
- Нөхөн сэргээлт хийж буй гадаргууг эхлээд үржил шимт хурдсаар, дараа нь ургамлын үндэс бүхий нөхөн сэргээгдсэн ерөнхий давхарга үүсгэх зорилгоор үржил шимтэй хөрсөөр хучих;
- Уурхайн зориулалтаар хийсэн хаалт, далан, шороон овоолгын хэрэггүйг нь тэгшилж засах замаар устгах, хэрэгтэйг нь үргэжлүүлэн ашиглах усжуулалтын сүлжээ болон бусад төрлийн гидротехникийн байгууламжуудыг нөхөн сэргээх;
- Шаардлагатай тохиолдолд биологийн нөхөн сэргээлтэд тохирохгүй хөрс чулуулгийг халхавч давхаргаар дараа нь үржил шимт хөрсөөр хучиж тэгшлэх;
- Үржил шимт хурдас ба хөрсөөр хучилт хийхийн өмнө бохирдсон хөрс болон хорт бодис агуулсан хурдас чулуулгийг хоргүйжүүлэх саармагжуулах арга хэмжээ авах;

Нөхөн сэргээлтийн ажлын баримтлах стандарт , аргачлал

Нөхөн сэргээлт MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”

MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага”

MNS5850-2008 Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

MNS5915-2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангиал

MNS5917-2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө уурхайн эдэлбэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг тодорхойлох нарийвчилсан судалгаа явуулах дараа нь уг судалгааны үр дүн болон бусад мэдээ мэдээлэлд үндэслэн ургамалжуулах ажлын чиглэлийг тогтоох, эцэст нь овоолгын талбайг хэлбэржүүлж шимт хөрсний үе үүсгэн ургамалжуулалтыг байгалийн аясаар буюу зохиомлоор тарьж ургуулах зэрэг дэс дараалтайгаар гүйцэтгэнэ.

ЕС. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд уурхайн ойролцоо тоосжилтыг бууруулах зорилгоор 300 ширхэг мод, бут сөөг тарина..

. АРАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

АРВАН НЭГ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдэхгүй болно.

12. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

12.1. Орчны хяналт – шинжилгээний хөтөлбөр

“Очирням” ХХК нь төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл болон холбогдох менежментийн гүйцэтгэлд хяналт- шинжилгээ хийх үүднээс энэхүү хөтөлбөрийг (ОХШХ)-ийг боловсруулан хэрэгжүүлнэ.

МУ-ын Байгаль орчныг хамгаалахтай холбогдох хууль тогтоомжийг үндэслэн боловсруулсан төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсанаар төслийн үйл ажиллагаанаас гарах аливаа сөрөг нөлөөллөөс сэргийлэх, түүнийг багасгах боломжтой юм. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ, хяналт-шинжилгээний хөтөлбөрийг олборлолт болон нөхөн сэргээлтийн үе шатад хийх бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаар, усны чанар, хөрс, амьтан, ургамлын асуудлыг онцлон анхааран авч үзлээ.

Олборлолтын үед болон дараа байгаль орчны хүчин зүйлүүд дээр нарийвчилан хяналт-шинжилгээний хөтөлбөртэй ажиллах ба байгаль орчны үзүүлэлтүүд, байршил, зүй тогтлын үечлэлийн хугацаа мөн хууль тогтоомжийн заалтын хэрэгжилт зэргийг хянах боломжтой.

Төслийг хэрэгжүүлэх явцад төслийн үе шатууд эдгээрээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, түүнийг байнга хянаж байх арга хэмжээг хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасан байна. Энэ хөтөлбөрийн дагуу “Очирням” ХХК нь Нийслэлийн БОАЖГ-тай хамтран үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах үүрэгтэй.

“Очирням” ХХК нь зохих журмын дагуу (ОХШХ)-г амжилттай хэрэгжүүлэх үүднээс мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй.

. Байгаль орчны Хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг жилийн дундаж зардал 290.0 мян.төгрөг байна.

Хүснэгт №12-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| Хяналт хийх үзүүлэлтүүд | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Нэгжийн өртөг, мян.төг | Нийт зардал, мян.төг | Баримтлах аргачлал | Стандарт, | Дээд доод хязгаар | |
|--|---|-------------------------------------|---------------------------|----------------------------|-----------------------|--|--|--|
| Агаарын чанар, бохирдлын мониторинг | | | | | | | | |
| Тоос: PM2.5, PM10, Нийт тоос Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Угаарын хий | Элс хайрганы ордоос салхины чигийн дагуу 100м, 500м-т | Жилд 1 удаа 2 дээж | Утааны хий, тоос | - | | MNS 0017-2-5-12:1988 MNS ISO 4221: 2002 MNS0012-1-003:1982 MNS 0017-2-5-11:1988 MNS 4048:1988 ISO 16017-1:2000 ISO 16362-2:2003 MNS 5365:2004 | 24 цагийн дундаж: Нийт тоос-150 мкг/м ³ PM2.5-50 мкг/м ³ PM10-100 мкг/м ³ SO ₂ -20 мкг/м ³ NO ₂ -40 мкг/м ³ CO-30000 мкг/м ³ | |
| | Ажилчдын кемпийн ойролцоо | | | 60.0 | 60.0 | MNS-5919:2008 MNS ISO 4226:2000 MNS ISO 4227:2002 MNS 4585:2007 MNS 5885:2008 | | |
| | Ил уурхай, хөрсний овоолгын ойролцоо | | | 60.0 | 60.0 | | | |
| Дүн /мян.төг/ | | 120.0 | | | | | | |
| Усны нөөц, чанар, бохирдлын мониторинг | | | | | | | | |
| Химийн ерөнхий шинжилгээний | Үндны ус авч хэрэглэж буй уст цэг | Судалгааны үед жилд 1 удаа | 1 дээж | 60.0 | 60 | MNS6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Газрын доорхи ус: pH-6.5 – 8.5 NH ₄ ⁺ 3.0 мгN/л NO ₂ – 1 мг/л NO ₃ ⁻ 50 мг/л PO ₄ – 3.5 мг/л Cl – 350 мг/л F – 1.5 мг/л SO ₄ -500 мг/л Mn-0.1 мг/л Ag-0.1 мг/л Fe-0.3 мг/л | |
| Дүн /мян.төг/ | | 60.0 | | | | | | |
| Хөрсний чанар, бохирдлын мониторинг | | | | | | | | |

“Бөхөг-Солонго” элс-хайрганы ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | | | | | | |
|---|--|---|-----------------------------|--------------|------|--|--|--|--|--|
| Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO_3), хөдөлгөөнт кали (K_2O), хөдөлгөөнт фосфор (P_2O_5), Шингэгдэсэн сууриуд Ca, Mg Хар тунгалааг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As) | Овоолго шорооноос 200 м-т Цэвэр хөрс Ажилчдын кемпийн ойролцоо Хог хаягдлын цэгийн хажууд | Жилд 1 удаа | Ерөнхий, хүнд металл | 55.0 | 55,0 | MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Pb-100 мг/кг Cd-3 мг/кг As-6 мг/кг Cu-100 мг/кг Zn-300 мг/кг | | | |
| | | | | - | - | | | | | |
| | | | | - | - | | | | | |
| | | | | - | - | | | | | |
| Дүн /мян.төг/ | | | | 110.0 | | | | | | |
| Ургамлан нөмрөгийн мониторинг | | | | | | | | | | |
| Унаган ургамал, ховор ургамал, таримал ургамлын хяналт | Шинээр ашиглалт явуулах талбай, нөхөн сэргээлт хийсэн байгалийн аясаар нөхөн ургалт явагдаж буй талбайд | Зүн, намрын улиралд хяналтын зорилгоос хамаарч давтамжийг тогтооно. | Ажиглалтын тогтмол цэгүүдэд | - | - | Ургамлын судалгааны арга зүй | - | | | |
| Дүн /мян.төг/ | | | | - | | | | | | |
| Амьтны аймгийн мониторинг | | | | | | | | | | |
| Зэрлэг хяналт амьтадын | Уурхайн ашиглалтын талбайн хэмжээнд болон уурхайн нөлөөллийн бүсэд | тогтмол | Ажиглалтын тогтмол цэгүүдэд | - | - | Амьтны судалгааны арга зүй | - | | | |
| Нийт /мян.төг/ | | | | 290.0 | | | | | | |

12.2 Сөрөг нөлөөлөл

Энэхүү төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд дараах сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Олборлолтын үеэр тодорхой хэмжээний газрын гадарга өөрчлөгдөж, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг устана.
- Олборлолтын үед агаарт тоос шороо дэгдэн, машин механизмын утаа орчны агаарыг бохирдуулна.
- Газрын доорхи усны нөөцөд нөлөөлж, ус бохирдож болзошгүй.
- Төслийн талбай орчмын хөрсний биологи, химийн шинж чанарт өөрчлөлт орж, машин механизмийн хөдөлгөөнөөр хөрс эвдрэлд орно.
- Шатахуун, тос тослох материал, техникийн хог хаягдал ба ахуйн хаягдлаар хөрс бохирдоно.
- Тодорхой хэмжээний бэлчээрийн талбайн ургамлын бүрхэвч устах буюу талхлагдах ба хөрс тээвэрлэлтийн үед тоос шороо нь орчмын ургамлын бүрхэвчид сөрөг нөлөөлөл учруулна.
- Ан амьтны амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тодорхойлсон төслөөс байгаль орчин нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах чиглэлээр хийх ажлуудыг сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд харуулав.

Уур амьсгалын нөхцөлөөс үүсч болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Төслийн орчны уур амьсгалын нөхцлөөс хамааран ордын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байдал, түүнээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зөвлөмжийг Хүснэгт 4-2-д харуулав.

Хүснэгт №12-2. Уур амьсгалын нөхцлөөс үүсч болзошгүй нөлөөллийн арилгах хэмжээ

| № | Төслийн үе шат | Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ |
|---|----------------------|--|
| 1 | Үйл ажилгааны үе шат | <ul style="list-style-type: none">• Төслийн район салхины ихтэй хур тунадасны эрчим ихтэй, эмзэг хөрстэй учир хөрсний элэгдэл, эвдрэлийг хамгийн бага байлгах арга хэмжээ авах;• Аадар бороо, мөндөр, аянга цахилгаантай үед техник хэрэгслийг талбайд гаргаж ажиллуулахгүй байх;• Үерийн урсац уурхайн ухашид орохгүй байх нөхцлийг бүрдүүлэх;• Хамгийн оновчтой арга хэмжээ бол цаг агаарын урьдчилан мэдээ болон аюулт ба гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаандаа хэвшүүлэх явдал юм;• Хүчтэй салхи шуургатай үед унаж эвдэрч болох байгууламжийг бэхлэх арга хэмжээ авах; |

Төслийөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Элс хайрганы ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх үед агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг үзүүлэв.

Хүснэгт №12- 1. Төслийөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

| № | Төслийн үе шат | Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ |
|---|----------------------|---|
| 1 | Үйл ажилгааны үе шат | <ul style="list-style-type: none">Ахуйн гаралтай хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тогтоосон хугацаанд зайлцуулаагүйгээс ялзарч муудан агаарт эвгүй үнэр гаргаж бохирдуулах тул хог хаягдаа тусгай саванд төрөлжүүлэн хадгалан хоёрдогч түүхий эдээр ашиглах боломжтой хэсгийг тушааж, хог хаягдаа тогтоосон хугацаанд нь зориулалтын цэгт зайлцуулж байх шаардлагатай;Ордыг ил уурхайн аргаар авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах учир уурхайн тээвэрлэлтэнд ашиглагдаж буй машин механизм, техникиүүдээс агаарыг бохирдуулагч их хэмжээний бодис ялгардаг. Үүнд хяналт тавьж тухайн техникийн хорт хий ялгаруулалтыг тогтоосон хэмжээнд нь барьж /боломжтой бол шүүлтүүр тавьж/ ажиллах шаардлагатай;Уурхайн дотоод замд хөрс болон элс-хайрга тээврийн автосамосвалын хөдөлгөөний дундаж хурд нь авто самосвалын овор жин, замын ачаалал, хөдөлгөөний эрчим, аюулгүй байдал зэргээс хамаарч ачаатай үед дунджаар 20-40 км/цаг, хоосон чиглэлдээ мөн 20-40 км/цаг байх;Бутлан ангилах хэсгээс тоосжилт үүсэх тул ажилчдыг амны хаалт зүүлгэж ажилчдын аюулгүй байдлыг хангах;Ашиглалтын нийт жилүүдийн турш уурхайн зам нь автотээврийг бүтээлтэй ажиллахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог учир уурхайн дотоод замыг сайжруулсан шороон зам болгон завсарлаж, нэгдсэн нэг маршрутын замаар тээвэрлэлт хийж, олон салаа зам гаргахгүй байж, замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах, ашиглалтын нийт хугацаанд дотоод замд засвар үйлчилгээ байнга хийх шаардлагатай;Хурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн технологийн процессын дагуу ухаж ачих, тээвэрлэх, овоолго хийх явцад тоосжилтыг багасгах зорилгоор тээвэрлэлт хийх зам талбай болон овоолгыг усаар шүршин тоосжилтыг бууруулах;Тоосжилт ихтэй үед төслийн районд ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор амны хаалт зэргийг ашиглан хэвшүүлэх;БОННУ-ний БОМТ (БОХШХ) тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад хийн хэмжилтийг хийж, тухайн орчны агаарын бохирдолтыг хянаж байх;Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцлийг хангаж, салхинд хийсэж тоосжилт үүсгэхээс урьдчилан сэргийлэх;Уурхайн бүх авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн агаарт гаргах хаягдалд ноогдуулах төлбөрийг төлөх;Мониторингийн хяналт явуулах өрөнхий удирдамжийг тус тайлангийн Байгаль орчны шаардлага, хяналт болон байгаль хамгаалах төлөвлөгөөнд дэлгэрэнгүй оруулсан байгаа болно;Төслийн талбайд ногоон байгууламжийн зурvas байгуулахБутлах үйлдвэрийн үйл ажиллагаанас тоос ихээр ялгарах тул бултлуурын хэсэгт тоос сорох вентилятор суурилуулахТүүхий эдийг олборлон тээвэрлэхдээ аль болох тоос шороо босохгүй байлгах |

| | | |
|--|--|--|
| | | арга хэмжээг авах, тээвэрлэх явцад их хэмжээний тоос босч байвал автомашинд бүтээлгээ болон хормой хийж өгөх; <ul style="list-style-type: none">• Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг шатаахгүй байх;• Төслийн талбайгаас хатуу хучилттай автозам хүртэлх 1.0 км сайжруулсан широон замыг хатуу хучилттай болгох |
|--|--|--|

Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Газрын гадарга болон хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн байдлаас үзэхэд элс хайргыг ил аргаар уурхайлан ашиглах, овоолго үүсгэх, элс хайрга тээвэрлэх нь их эрчимтэй нөлөөлөх байна. Иймд сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээг байнга хэрэгжүүлэх шаардлагатай юм

Хүснэгт №12- 2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

| № | Төслийн үе шат | Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ |
|---|-----------------------|---|
| 1 | Барилгын ажлын үе шат | <ul style="list-style-type: none">• Газар ашиглалтыг зөвхөн батлагдсан зураг төсөл, төлөвлөгөөний дагуу явуулж ашиглалтын дор өртөх газрын хэмжээг хамгийн бага хэмжээнд байлгах ба бүх төрлийн зориулалтаар газар ашиглалт явуулахын өмнө талбайн шимт хөрсийг урьдчилан хамгаалах арга хэмжээ авах; |

| | | |
|---|----------------------------|---|
| | | <ul style="list-style-type: none"> Зарим төрлийн ангилж ялгасан хог хаягдлыг түр хадгалах цэгийг стандартын дагуу зохион байгуулах /тосоор бохирдсон хөрс хадгалах талбай/; Ажиллагсдын кемпээс гарах хатуу хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах боломжтой боломжтой зориулалтын тусгай цэгт түр хадгалан, хуванцар усны сав гэх мэт хоёрдогч түүхий эдийг төвлөрсөн цэгт тушаах , бусад дахин ашиглагдахгүй хог хаягдлыг тогтоосон цэгт байгаль орчинд халгүй байдлаар зайлзуулах; Уржил шимт хөрс, хоосон чулуулгийн овоолгуудыг ноёлох салхины чиглэлд хөндлөн байрлалтайгаар 5-10 м, 5м-ээс ихгүй өндөртэй, 30-50м орчим урттай, хажуугийн налуу 20 градусаас ихгүй, оройн хэсгийг бага зэргийн бөмбөгөрдүү тэгшивтэр байхаар дагтаршуулан нуруулдаж байршуулах; Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг нийслэлийн байгаль орчны байгууллага мөн төв аймгийн байгаль орчны газартай зөвшилцөн тохиролцо замаар тогтооно; Уржил шимт хөрсний овоолгыг хадгалах зориулалттай агуулах талбайг сонгоходоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэлд орох нөхцөлийг хамгийн бага байлгахаар төлөвлөх; |
| 2 | Үйл ажилгааны үе шат | <ul style="list-style-type: none"> Уржил шимт хөрсийг хамгаалахын тулд хөрсний овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийх, тохиромжит ургамлын үр цацах, гадаргуугийн бүрхэвч бий болгох, хажуу бэлийг хамгаалах; Хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэхийн тулд сөрөг нөлөөлөлд өртсөн хөрсийг тухай бүр сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авч байх; Уурхайн үйл ажиллагаа аюулгүйгээр явуулах нөхцөлийг хангахад гарцаагүй шаардлагатайгаас бусад нөхцөлөөр газар, хөрсийг эвдрэлд оруулахгүй байх, эвдрэлд орох газрын хэмжээг хамгийн бага байлгах удирдлага зохион байгуулалт, техник технологийн арга хэмжээг байнга авч байх; Олон салаа зам гаргахгүй байх ,тээвэрлэлт замын маршрутыг тодорхой тогтоож тэмдэгжүүлэх; Шимт хөрсний овоолгыг “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт ” MNS 5916:2008 стандартыг мөрдлөг болгох; |

Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Ус хэрэглээнд газрын доорхи ус хэрэглэхээс гадна ус бохирдуулах нөхцөл үүсэх тул газрын доорхи усны горим чанар, нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулахад онцгой анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт №12- 3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

| № | Төслийн үе шат | Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ |
|---|-----------------------|--|
| 1 | Барилгын ажлын үе шат | <ul style="list-style-type: none"> Үерийн хамгаалалтын төлөвлөлтийг оновчтой гүйцэтгэх; |
| 2 | Үйл ажилгааны үе шат | <ul style="list-style-type: none"> Ахуйн бохир усыг цэвэршүүлэн дахин ашиглах боломжийг судалж хэрэгжүүлэх арга хэмжээ авах; Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан ажиллагсдад байгальтай зохицой харьцах, усны нөөцийг арвилан хэмнэх талаар мэдээлэл хийж хяналт тавьж ажиллах; Тээврийн замын тоосжилтыг дарах арга хэмжээг аваходаа зөвхөн технологийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий замууд болон тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд тоос дарах усалгааг ашиглах; |

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Зайнаас тандан судлалын аргаар тодорхойлсон үр дүнгээс үзэхэд төслийн талбай орчмын ургамлан нөмрөг нь хүний үйл ажиллагаанд нилээд хэмжээгээр өргөгдсөн байна. Ургамлан нөмрөгт шууд нөлөөлөл үзүүлэх хүчин зүйл нь хөрс бүрхэвчид үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой. Иймд хөрс хамгаалалын арга хэмжээг сайн авч хэрэгжүүлэн, олборлолтын үйл ажиллагаа дууссаны дараа техникийн нөхөн сэргээлтийн стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх нь цаашид ургамлан нөмрөг унаган төрхөндөө ороход чухал ач холбогдол бүхий болохыг анхаарах хэрэгтэй юм. Шууд бус нөлөөлөл буюу тоосонцороос ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам нь агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хэр сайн авч хэрэгжүүлэхээс хамаарна. (Хүснэгт 4-6)

Хүснэгт №12- 4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

| № | Төслийн үе шат | Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ |
|---|-----------------------|--|
| 1 | Барилгын ажлын үе шат | <ul style="list-style-type: none">Хөрс хуулалтанд өртөх газрын ургамлан нөмрөгийн судалгааг хийж ховор болон ховордож буй ургамлын тохиолдоц, тархалтын хувийг тогтоож, хамгаалах арга хэмжээ авах; |
| 2 | Үйл ажилгааны үе шат | <ul style="list-style-type: none">Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ховор болон ховордож буй ургамлын боломжит төрөл зүйлүүдээр тариалалт хийх, эсхүл ашиглалт явуулах талбайгаас нөхөн сэргээлт хийгдэж буй талбай руу шилжүүлэн суулгах; |
| 3 | Хаалтын үе | <ul style="list-style-type: none">БОМТ-ний хүчинтэй хугацаанд хаалт хийгдэхгүй болно. |

Төслөөс үүсэх физик бохирдол, хог хаягдлыг бууруулах арга хэмжээ

Уурхайн үйл ажиллагааны явцад машин, техник хэрэгслийн үйл ажиллагаа, ахуйн хатуу, шингэн хог хаягдлаар хөрсийг бохирдуулахгүй байх, ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулахад доорхи дурьдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. нь

Хүснэгт №12- 5. Физик бохирдол, хог хаягдлыг бууруулах арга хэмжээ

| № | Төслийн үе шат | Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ |
|---|----------------------|---|
| 1 | Үйл ажилгааны үе шат | <ul style="list-style-type: none">Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин, механизмыг техникийн тогтмол засвар үйлчилгээнд оруулж орчин тойронд дуу чимээний гаж нөлөө үзүүлэхгүй байх арга хэмжээ авах;Машин техникээс тос, тосолгооны материал, шатахуун зэрэг хөрсөнд асгарч бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээ авах, асгарсан тохиолдолд цаг алдалгүй хөрсийг цэвэрлэн бодисыг саармагжуулах;Уурхайд ашиглах машин механизмд ашигласан тос, тосолгооны материалын сав баглаа боодол, мод, хуванцар эд материал, ашигласан батерей, картон болон хуванцар баглаа боодлын сав, нөөцлүүрт байгаа хаягдал, ашигласан маслын шүүр, аккумлятор, зэрэг хаягдлыг дахин ашиглуулахаар нийлүүлэгчид өгөх ба дахин боловсруулагдахгүй, ашиглагдахгүй хог (органик хаягдал) хаяглуудыг зөвшөөрөл бүхий орон нутгаас заасан цэгт зөөвөрлөн хоргүйжүүлж устгана;Уурхайд ажиллах ажиллагсаас гарах ахуйн хатуу хог хаягдлыг ил задгай хаялгүйгээр орон нутгийн захиргааны шийдвэрийн дагуу хог хаях цэгт хүргэх дарж булахАжилчдын эрүүл мэндийг хамгаалж, дуу чимээний намсгагч тогтмол өмсүүлэх; |

| | | |
|--|-----------------|---|
| | | <ul style="list-style-type: none">Дуу чимээ үүсгэгчийн тархах замд хаалт хийх, машин техник технологид дуу намсгагч тавих;Төслийн талбайд байрлах нүхэн жорлонг халдвартгүйжүүлж стандартын шаардлагын дагуу дарж булахАхуйн шингэн хаягдал цуглуулах байгууламжийг экологид ээлтэй стандартын шаардлагад нийцүүлэн барьж байгуулахОдоо ашиглагдаж буй ажилчдын бие засах газар нь стандартын шаардлага хангахгүй байгаа тул дарж булан эрүүл ахуйн хяналтын байгууллагаас зөвшөөрсөн газруудад хаагдаг хаалгатай нэг хүнд 1.2-2 м²-с багагүй талбай бүхий бие засах газар байгуулах;Доторлогоотой бохир ус цуглуулах сан байгуулж соруулан зайлцуулдаг байх |
| | Агаалтын үе шат | <ul style="list-style-type: none">БОМТ-ний хүчинтэй хугацаанд хаалт хийгдэхгүй болно. |

Төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

